



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 08 сарын 29 өдөр

Дугаар А/551

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 14.2.12, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны "Аймгийн 2019 оны төсөв батлах тухай" 8/04 дүгээр тогтоол, Биеийн тамир, спортын газрын 2019 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 1/295 дугаар албан бичгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улаанбаатар хотод 2019 оны 09 дүгээр сарын 09-15-ны өдрүүдэд зохион байгуулагдах Монголын Хүүхдийн спортын YI Их наадмын шигшээ тэмцээнд аймгаас оролцох спортын 12 төрлийн 128 тамирчин, 22 дасгалжуулагч, багш нарт шаардагдах зардлын санхүүжилтэд 24300.0 мянган төгрөг /Хорин дөрвөн сая гурван зуун мянган/-ийг хавсралтаар баталж, зарцуулсугай.

2. Тус арга хэмжээнд зарцуулагдах 24300.0 мянган төгрөгийг аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2019 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний жагсаалтын 5.17 дахь заалтын "Спортын аварга хөтөлбөр"-өөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Даваадорж/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ нарт тус тус зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

D/Zax-A/551-Da

02 02782

Аймгийн Засаг даргын 2019 оны
08 дугаар сарын 29-ний өдрийн
А/551 дүгээр захирамжийн
хавсралт

МОНГОЛЫН ХҮҮХДИЙН СПОРТЫН 6 ДУГААР ИХ
НААДМЫН ШИГШЭЭ ТЭМЦЭЭНД АЙМГААС ОРОЛЦОХ
ТАМИРЧИД, ДАСГАЛЖУУЛАГЧ, БАГШ НАРЫН
ЗАРДЛЫН ТООЦОО

д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Тоо	Нэг бүрийн үнэ /төгрөгөөр/	Нийт үнэ мянган төгрөгөөр
1	Ховдоос Улаанбаатараас Ховдын очих, буцах замын зардал	Тамирчид	128	142000.00	18176.0
		Дасгалжуулагч, багш	22	142000.00	3124.0
		Дүн			21300.0
2	Малгай, подволк	Хүн	150	20000.00	3000.0
3	Нийт дүн				24300.0